



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 294

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн санхүүжилтээр барьж ашиглалтад оруулсан /Боловсрол, шинжлэх ухааны сайдын багц/ нийт 4,433,352,825.00 (дөрвөн тэрбум дөрвөн зуун гучин гурван сая гурван зуун тавин хоёр мянга найман зуун хорин тав) төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг хавсралтад заасны дагуу Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнд эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал М.Бямбасүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх, бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Барилгад ногдох газрын эзэмших эрхийг Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн нэр дээр шилжүүлэх ажлыг зохион байгуулах;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-г үүрэг болгосугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001617  
16-r\_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн  
194 дугаар тогтоолын хавсралт



**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН  
УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭНД  
БҮРТГЭХ ХӨРӨНГӨ**

Д/д	Хөрөнгийн нэр	Хөрөнгийн нийт үнэ (төгрөг)	Барилга байгууламж ашиглалтад оруулсан улсын комиссын актын дугаар
1	Шинжлэх ухааны судалгааны лаборатори, спорт танхимын барилгын "А" блок	4,433,352,825.00	2024.02.16 БА-030/2024
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>4,433,352,825.00</b> <b>(дөрвөн тэрбум</b> <b>дөрвөн зуун гучин</b> <b>гурван сая гурван зуун</b> <b>тавин хоёр мянга</b> <b>найман зуун хорин</b> <b>тав)</b>	